МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.08.28 № 13

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЙД Ц.ТУВААН ТАНАА

Халзан бүрэгтэй төслийн талаар
асуулга тавих тухай

Ховд аймгийн Мянгад сумын нутаг дэвсгэрт байрлах Халзан бүрэгтэй нэрт газарт 6911А, Ар хүрэн нэрт газарт 12335А дугаартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Монголиан нэйшнл рийр ийрт корп” ХХК-ний үйл ажиллагааг түр хугацаанд зогсоох шийдвэрийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар шийдвэрлэсэн.

Ингэхдээ “Орон нутгийн иргэдийн санал хүсэлтэд нийцүүлэн, “Халзан бүрэгтэй ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах эсэхийг шийдвэрлэх”-ээр Монгол Улсын Засгийн газар шийдсэнийг тухайн үеийн салбарын сайд Ж.Ганбаатар нийтэд мэдэгдсэн.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас Ховд аймаг, Завхан аймаг, Говь-Алтай аймгийн иргэдийн эрүүл мэнд, мал амьтан, байгалийн эко системд ноцтой нөлөөлөх эрсдэлтэй тус төслийн үйл ажиллагааг сэргээх бодлого баримтлах болсныг Ховд аймгийн Мянгад сумын иргэд төдийгүй Ховд аймаг, Баруун бүс иргэдийн зүгээс хүчтэй эсэргүүцэж байгаа тухай санал, гомдлоо удаа дараа уламжилж байна. Миний бие иргэдтэйгээ нэг байр суурьтай байгаа болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын гишүүн миний бие нийт ард түмний элч, төлөөлөгч байх үүргийнхээ дагуу болон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 12 дугаар зүйлийн 12.1 дэх тус тус хэсгийг үндэслэн Танд хандаж, дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. 2023 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон харьяа агентлагаас Ховд аймгийн Мянгад нутаг дэвсгэр Халзан бүрэгтэй нэрт газарт 6911А, Ар хүрэн нэрт газарт 12335А ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж

20240036

байгаа “Монголиан нэйшнл рийр ийрт корп” ХХК-ний үйл ажиллагааг зогсоох шийдвэр хүчинтэй хэвээр байгаа эсэх талаар;

2. “Монголиан нэйшнл рийр ийрт корп” ХХК –д Ховд аймгийн Мянгад сумын нутаг дахь Халзан бүрэгтэй нэрт газарт 6911А, Ар хүрэн нэрт газар 12335А талбайнуудад ашиглалтын зөвшөөрлийг хууль зөрчиж олгосон байсан тул Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Геологи, уул уурхайн техникийн хяналтын улсын ахлах байцаагч П.Эрдэнэчулууны 2012 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 21-05/003/675 дугаартай “Улсын ахлах байцаагчийн дүгнэлт” хүчинтэй байгаа эсэх талаар;
3. Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Геологи, уул уурхайн техникийн хяналтын улсын ахлах байцаагч П.Эрдэнэчулууны 2012 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 21-05/003/675 дугаартай “Улсын ахлах байцаагчийн дүгнэлт”-д дурдсаны дагуу “Монголиан нэйшнл рийр ийрт корп” ХХК – д олгогдсон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохгүй байгаа талаар;
4. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар шийдвэрлэсний дагуу “Халзан бүрэгтэй ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах эсэх” талаар орон нутгийн иргэдийн саналыг авсан эсэх талаар;
5. “Монголиан нэйшнл рийр ийрт корп” ХХК-ийн Ховд аймгийн Мянгад сум, Халзан бүрэгтэй нэрт газарт явуулсан ашигт малтмалын /өрөмдлөгийн болон бусад/ үйл ажиллагааны улмаас тус компанийн эзэмшлийн 6911А, 12335А талбай дахь цацраг идэвхт бодисын идэвхийн хэмжээнд өөрчлөлт байгаа эсэх, энэ нь хүн амьтан хүрээлэн буй орчинд аюулгүй эсэх талаар дүгнэлт гарсан эсэх талаар;
6. Тус төслийн үйл ажиллагааг үргэлжлүүлэхийг дэмжсэн талаар Мянгад сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцсэн эсэх болон төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тухай бүрд хуульд заасны дагуу батлуулсан эсэх талаар;
7. Халзан бүрэгтэй уулын орд бүхий газар нь Ховд голоос 8 км, Хар ус нуураас 19 км, Буянт голоос 20 км, Мянгад сумын төвөөс 19 км зайд оршдог тул тус ордоос цацрагийн идэвхт бүхий бодис алдагдсан тохиолдолд Хар ус нуур, Хар нуур, Дөргөн нуурын ай саваар нутаглаж байгаа Ховд аймаг, Завхан аймаг, Говь-Алтай аймгийн иргэдийн эрүүл мэнд, мал амьтан, байгалийн эко системийг алдагдуулах эрсдэлтэй тул Олон улсын байгууллагаар Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх боломжтой эсэх талаар;
8. “Монголиан нэйшнл рийр ийрт корп” ХХК-ний эзэмшигч компани болон эцсийн өмчлөгчийн мэдээлэлд 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр өөрчлөлт орж, тус компанийн хувь эзэмшигчээр Канад Улсын “Суприм 17 холдинг лимитед” ХХК бүртгэгдсэн байна. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг эзэмшигч компанийн эцсийн өмчлөгч өөрчлөгдөхөд татварын хууль тогтоомжид заасны дагуу холбогдох татварыг батлагдсан аргачлал, тооцооллын дагуу төлүүлсэн эсэх талаар;

20240036

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,



УЛСЫН ИХ ХУРЛЫН

ГИШҮҮН З.МЭНДСАЙХАН